



Food and Agriculture
Organization of the
United Nations



БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ –2024 оны 07 сар

Монгол улсад жимс, жимсгэний үйлдвэрлэлийн нэмүү өртөгийн сүлжээ байгуулах хэрэгцээ

ТАНИЛЦУУЛГА¹

Жимс, жимсгэнэ нь хүн амын эрүүл мэнд, хүнс, гоо сайхны бүтээгдэхүүнд зайлшгүй ордог, олон төрлийн амин дэм, биологийн идэвхт бодис агуулдаг нэн чухал таримал юм. Жимс, жимсгэний үйлдвэрлэл нь олон жилийн уйгагүй хөдөлмөр, хөрөнгө санхүүжилт, туршлага, ур чадвар шаарддаг бөгөөд төр засгаас тууштай, урт хугацааны тогтвортой дэмжлэг үзүүлж байж үр дүнд хүрдэг онцлогтой. Монгол Улсын өнөөгийн жимс хүнсний ногооны хэрэгцээний дөнгөж 5 хувийг дотоодын үйлдвэрлэл, үлдсэн 95 хувийг импортийн нийлүүлэлт бүрдүүлдэг байна. Нийт импортлож байгаа жимс жимсгэний 50 гаруй хувь нь алим, лийр, тоор, чавга зэрэг үрт болон яст жимс болон жүржийн төрөл, усан үзэм мөн зонхилж буй бөгөөд чацаргана (102,781 тонн), үхрийн нүд (61,669 тонн), бусад төрлийн жимс, жимсгэнэ (51,391 тонн) зэрэг нийлбэр дүнгээр 215,841 тонн ургац авах хэрэгцээ бий. 2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 3000 орчим тонн жимс, жимсгэний ургац хураасны 970 тонн нь баруун бүсийнх байгаа нь тухайн бүс дэх нийт жишсэн хүн амд шаардлагатай жимс, жимсгэний 3.7 хувийг хангаж байна.

Манай орны хувьд баруун бүс нутаг (Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий аймаг) байгалийн зэрлэг болон таримал жимс, жимсгэнэ, ялангуяа чацарганы ихээхэн нөөцтэй. Мөн бусад бүс нутагтай харьцуулахад 1990-ээд оноос өмнө Говь-Алтай аймгийн Бигэр суманд жимсний дарсны үйлдвэр байгуулсан хуучны дэд бүтэцтэй, жимс, жимсгэний төрөл бүрийн сорт нутагшуулан, тарьж байгаа туршлагаар илүү байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн СКАЛА² төслийн хүрээнд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, Монгол Улсын ҮТХН-тэй (Үндэсний тодорхойлсон хувь нэмэр) уялдуулан хөдөө аж, ахуй, газар ашиглалтын салбарт суурь өөрчлөлт авчрах уур амьсгалын арга хэмжээг хэрэгжүүлэх системийн төвшний үнэлгээ (СТҮ)³-г хийж байна. Дээр дурдсан дотоодын жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, шаардлагатай эрэлтийг нөхөх, нэмүү өртгийн сүлжээг бий болгон өргөтгөх зайлшгүй хэрэгцээнд тулгуурлан Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жимс, жимсгэний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ хийх СТҮ-ний судалгааны талбараар баруун бүс нутгийг сонгож “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жимс, жимсгэний сортыг тодорхойлох, газрын тохиромжтой байдлын үнэлгээ” СТҮ-г тус төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

¹ Энэхүү бодлогын зөвлөмжийг Хөдөө аж ахуйн сургуулийн (ХААИС) харьяа Агроэкологийн сургуулиас 2023 онд гүйцэтгэсэн “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жимс, жимсгэний сортыг тодорхойлох, газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-нд суурилан боловсруулав.

² Үндэсний тодорхойлсон хувь нэмэр болон үндэсний дасан зохицох төлөвлөгөөний зорилтыг Хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ахиулахад дэмжлэг үзүүлэх төсөл (СКАЛА)

³ Системийн төвшний үнэлгээ нь төрөл бүрийн засаг захиргааны хил хязгаар, газар зүйн хязгаарлалтаас үл хамааран нийгэм, экологи, эдийн засаг, улс төрийн өнцөгөөс уур амьсгалын эрсдэл, шийдлийг тодорхойлж, илрүүлэн үнэлж, олон зорилтыг (хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын тэсвэртэй байдал, хүртээмжтэй амьжиргаа, орлого бүрдүүлэлт, байгаль орчны нөхөн сэргээлт, нүүрстөрөгчийн шингээлт) биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрэмбэлэн тогтоох зорилготой.

Баруун бүсийн жимс, жимсгэний тариалалтын тухай

А. Орон нутгийн жимс, жимсгэний эрэлт

Баруун бүсийн 2022-2050 он хүртэлх жишсэн хүн амын жилийн физиологийн хэрэгцээг үндэслэн жимс, жимсгэний хэрэгцээт байдлын өсөлтийг үнэлэхэд (Хүснэгт 1), 2040 он гэхэд чацаргана 3,426 тонн, үхрийн нүд 2,049 тонн, бусад төрлийн жимс, жимсгэнэ 1,708 тонн, нийт жимс, жимсгэний хэрэгцээ 7,183 тонн, 2050 он гэхэд нийт жимс, жимсгэний хэрэгцээ 12,326 тонноор тус тус нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 1 – Монгол Улсын Баруун бүсийн жимс, жимсгэний хэрэгцээт байдлын өсөлт (2022–2050), тонноор


ТӨРӨЛ	ХЭРЭГЦЭЭ (ТОНН)		ӨСӨЛТ (ТОНН)	ХЭРЭГЦЭЭ (ТОНН)		ӨСӨЛТ (ТОНН)	ХЭРЭГЦЭЭ (ТОНН)		ӨСӨЛТ (ТОНН)
	2022	2030		2022	2040		2022	2050	
ЧАЦАРГАНА	12,416	13,879	1,463	12,416	15,842	3,426	12,416	18,291	5,875
ҮХРИЙН НҮД	7,456	8,328	872	7,456	9,505	2,049	7,456	10,975	3,519
БУСАД	6,213	6,940	727	6,213	7,921	1,708	6,213	9,145	2,932
НИЙТ	26,085	29,147	3,062	26,085	33,268	7,183	26,085	3,8411	12,326

Эх сурвалж: СТУ, 2023

Судалгаанд хамрагдсан нийт нутгаар жилийн агаарын температурын дундаж -5.2°C -аас 4.4°C , хур тунадасны хэмжээ 55-268 мм орчимд хэлбэлздэг бөгөөд дулааны улирал харьцангуй удаан үргэлжилдэг байна. Энэ нөхцөл нь Монгол Улсын баруун бүсийн байгаль, экосистем нь бусад бүстэй харьцуулахад жимс, жимсгэнэ, ялангуяа чацаргана тариалахад хамгийн тохиромжтой орчныг бүрдүүлдэг. Баруун бүсийн жимс, жимсгэний тариалалтын онцлог нь талбайг голчлон байгалийн бэлчээрт байгуулдаг. Энэ нь усалгааны системтэй жимс, жимсгэний тариалалт хийх талбайг сонгохдоо тухайн газрын байгаль орчин, уур амьсгалын хүчин зүйлсийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Иймд СТУ-ээр усалгааны системтэйгээр жимс, жимсгэнийг тариалсан талбайн байгаль орчны өөрчлөлтийг байгалийн бэлчээрт тарьсантай харьцуулсан судалгаа хийхээр зорив.

Эрэлтийг тооцохдоо хүн амын өсөлтийн жишгийг харьцуулан Баруун бүсийн хүн амын өсөлтийг тооцсон⁴ (График 1).

График 1 – Баруун бүсийн хүн амын өсөлтийн таамаглал, мянган хүн амаар



Бүсийн хэмжээнд хүн ам өсөж байгаа ч цалингийн ялгаатай байдлаас хамааран хөдөлмөрийн насны ихэнх иргэд хөдөө аж ахуйн салбарт ажиллахаас илүүтэйгээр Ховд аймгийн Хөшөөтийн нүүрсний уурхайд ажиллах сонирхолтой байна. Энэ нь тухайн бүсэд мэргэжлийн аргонимич хүрэлцээ муу байгаагийн сацуу жимс, жимсгэнэ тариалах ажиллах хүчний хомсдлыг бий болгож байна.


⁴ Монгол Улсын Статистикийн үндэсний хорооны 2022 оны жилийн эцсийн хүн амын тооллого дээр үндэслэв.

Тиймээс дээр дурдсан 2050 он хүртэлх хүн амын өсөлттэй уялдан нэмэгдэх эрэлтийг хангахын тулд жимс, жимсгэний тариалалт, нутагшуулалт, ургац хураалттай холбоотой мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, газар тариалан эрхлэх урт хугацааны үр өгөөжийн талаар иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай.

В. Орон нутгийн нэмүү өртгийн сүлжээний дутагдалтай байдал

Баруун бүсийн жимс, жимсгэний зах зээлд ихэвчлэн жижиг аж ахуй нэгж, өрхийн аж ахуй давамгайлах хандлагатай. Орон нутгийн жимс, жимсгэнэ тариалагчдад хөрөнгө оруулалтын тохиромжгүй, нарийн төвөгтэй эрхзүйн зохицуулалт, шалгуур өндөртэй хүртээмжгүй банкны зээл, урамшуулал, хөнгөлөлт дутмаг, бичиг баримт бүрдүүлэлт төвөгтэй, олон дамжлагатай, барьцаа шаарддаг зэрэг төрөл бүрийн хүчин зүйлсээс шалтгаалж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтаа өргөжүүлэх боломж тааруу байдаг байна. Орон нутгийн нэмүү өртгийн сүлжээ байгуулах, тариалалтаа өргөжүүлэхэд жимс, жимсгэнэ тариалагчдад тулгарч буй түгээмэл саад бэрхшээлийг доор үзүүлэв (График 2).

График 2 – Баруун бүсийн жимс, жимсгэнэ тариалагчдад тулгарч буй нийтлэг саад бэрхшээл, хувиар



Эх сурвалж: СТУ, 2023

Өнөөгийн нөхцөлд зөвхөн бага хүүтэй буюу хөнгөлөлттэй зээлийн шугамыг ашиглаж байгаа ч энэ нь жижиг аж ахуйн нэгж, өрхүүдэд хүртээмж, олдоц муу, барьцаалах хөрөнгө байхгүй, банкнаас шаардаж байгаа баримт бичиг бүрдүүлэлтийн талаар ойлголт, мэдлэг дутмаг учир орон нутгийн нэмүү өртгийн сүлжээг нягтруулахад мэдэгдэхүйц хувь нэмэр оруулж чадахгүй байна.

Одоо хэрэгжиж байгаа үндэсний хөдөлгөөн, хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-тай уялдуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээ хөгжүүлэх "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Тэрбум мод", "Эрүүл Монгол хүн" гурван тулгуур үндэсний хөдөлгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж байна.⁵

Засгийн газраас "... жимс, жимсгэний төрөл зүйл, үйлдвэрлэл нэмэгдүүлэх, чацарганы тариалалтыг 10,000 га талбай, бусад төрлийн жимс, жимсгэний тариалалтыг 2,000 га талбайд хүргэх, иргэдээ экологийн цэвэр, шим тэжээлтэй жимс, хүнсний ногоогоор хангаж, импортыг бууруулан орлогын эх үүсвэр нэмэгдүүлэх экспортыг чадавхийг сайжруулах" зорилготой "Чацаргана" /2010-2016/, "Жимс жимсгэнэ" /2018-2022/ үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн.⁶

⁵ Advancing "Healthy Mongolian" National Campaign to the Next Level (montsame.mn)

⁶ Жимс, жимсгэний үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 08-р сарын 9-ны өдрийн 223-р тогтоол


Эдгээр үндэсний хөтөлбөрийн үр дүнгээс харахад Монгол орны экологийн цэвэр хөрс, уур амьсгалын орчинд ургасан эмийн ургамал, жимс жимсгэнэ, хүнсний ногоо, тэжээлийн ургамлыг экспортод гаргах боломж өндөр, эрэлт хэрэгцээ их байна.⁷ Мөн баруун бүсэд Ховд аймгийн Булган суманд таримал жимсний станцыг анхлан “Жимс, ойн турших станц” байдлаар говьд жимс жимсгэний аж ахуйг хөгжүүлэх боломжийг судлах зорилготой байгуулж байжээ.

Зөвлөмж

1. *Жимс, жимсгэнэ тариалахад тохиромжтой байршил, нутагшуулах боломж өндөртэй сорт*

Баруун бүсийн жимс, жимсгэнэ тариалах тохиромжтой байршлын үнэлгээг 2023 онд СТУ⁸-ний аргачлал ашиглан ХААИС-ын Агроэкологийн сургууль гүйцэтгэсэн. Нэгдсэн үнэлгээний зургийг радиометрийн заслын тусламжтайгаар 0-255 хооронд утга авхуулж засвар хийж зурагласан (График 3). Тохиромжтой байдлын үнэлгээний дүнгээр тухайн газар нутагт өндөр утга авах тусам тохиромжтой, бага утга авах тусам жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдал буурч байгаа үр дүн гарав.

График 3 – Жимс, жимсгэнэ тариалах тохиромжтой байдлын үнэлгээний зураг



Эх сурвалж: СТУ, 2023

СТУ-ний үр дүнд, баруун бүсэд алимны 13, чавганы 5 сортыг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нутагшуулах боломж өндөртэй гэж тодорхойлсон (Хүснэгт 2).

⁷ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жимс, жимсгэний сортыг тодорхойлох, газрын тохиромжтой байдлын үнэлгээ, ХААИС, Агроэкологийн сургууль, 2023

⁸ СКАЛА төслийн эхлэлийн үе шатанд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааг тодорхойлохын тулд а) нөхцөл байдлын дэвсгэр судалгаа, б) уур амьсгалын арга хэмжээний матрикс (CAR) гэсэн хоёр үндсэн үнэлгээ хийсэн. Энэхүү үнэлгээний зорилго нь а) олон талын оролцоотойгоор газар ашиглалт, хөдөө аж ахуйн салбарт ҮТХН (Үндэсний тодорхойлсон хувь нэмэр) болон ҮДЗТ-ний (Үндэсний дасан зохицох төлөвлөгөө) зорилтыг хэрэгжүүлж болохуйц, өөрчлөлт авчрах уур амьсгалын шийдэл бий болгох, б) СКАЛА төслийн зорилготой уялдуулан тогтолцооны суурь өөрчлөлтөд нөлөөлөх боломжтой газар ашиглалт, хөдөө аж ахуйн салбарын ҮТХН болон ҮДЗТ-ний уур амьсгалын нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг (тэргүүлэх талбар) тодорхойлох в) уур амьсгалын үндэслэл, системийн хандлага, хувийн хэвшлийн оролцоо, жэндэрийн эрх тэгш байдал, нийгмийн оролцоо, тогтвортой хөгжил, бодлогын уялдаа, технологи, санхүүгийн инноваци гэсэн өөрчлөлтийн долоон үндсэн хэмжээсээр тухайн нэн тэргүүний уур амьсгалын арга хэмжээ өөрчлөлт авчирхуйц байгаа эсэхийг үнэлэх г) үнэлгээ өгсөн уур амьсгалын арга хэмжээ тус бүрийн өөрчлөлт авчрах боломжийг тооцоолох байв. Тухайн хоёр үнэлгээний үр дүнд СКАЛА төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлсон бөгөөд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жимс, жимсгэний сортыг тодорхойлох, газрын тохиромжтой байдлын үнэлгээ” нь Монгол Улсад хэрэгжүүлэх системийн төвшний үнэлгээний нэгээр сонгогдсон.

Хүснэгт 2 - Монголын баруун бүсэд нутагшуулах боломж өндөртэй алимны 13 сорт, чавганы 5 сорт

#	АЛИМ	ЧАВГА
1	Боровинка	Манжурская красивица
2	Антановка	Падорок чемальская
3	Пепин шафранный	Памяти Путова
4	Алтайская чемалская	Жёлтая хопти
5	Алтайская пурпуровая	Опота
6	Папировка	
7	Алтайская румяная	
8	Осеннее кравченко	
9	Янтарка алтайская	
10	Ранетка пурпуровая	
11	Сибирское золото	
12	Алтайская десертная	
13	Яблоня алтайское пурпуровое	

С. Бүсийн төв (regional hub), жимс, жимсгэний дагалдах бүтээгдэхүүн

Баруун бүсийн таван аймагт хийсэн тандан судалгааны 84 түүврээс үзэхэд жимс, жимсгэний бизнес эрхэлсэн хугацаагаар 92 хувь нь 6 хүртэл жил, 92.7 хувь нь 6-аас дээш жил гэж хариулжээ. Судалгаанаас үзэхэд жимс тариалагчид жимс, жимсгэнэ тариалахаас гадна жимсний дагалдах бүтээгдэхүүн болох үр, суулгац, навч борлуулах зэрэг бизнес эрхэлдэг байна. Энэ нь боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өрх гэр түүхий эд нийлүүлэхээс гадна, үйлдвэрлэлийн түвшинд ажиллах боломж олгоно (Хүснэгт 3).

Хүснэгт 3 - Жимс/жимсгэний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүвэрт оролцогчдын эзлэх хувиар

ТҮҮВЭРТ ОРОЛЦОГЧИД	БҮТЭЭГДЭХҮҮН							ОРОЛЦОГЧДЫН ТОО
	Жимс	Үр	Суулгац	Навч	Жимсний тос	Чанамал	Жүүс	
АЙМАГ								
Баян-Өлгий	80.0	6.7	20.0	6.7	6.7	6.7	33.3	15
Говь-Алтай	88.2	0.0	17.6	0.0	0.0	23.5	11.8	17
Завхан	100.0	16.7	50.0	0.0	0.0	0.0	0.0	6
Увс	96.0	8.0	20.0	4.0	32.0	12.0	40.0	25
Ховд	100.0	0.0	11.1	0.0	0.0	5.6	5.6	18
БИЗНЕС ЭРХЭЛСЭН ЖИЛ*								
6 хүртэлх жил	92.0	0.0	16.0	0.0	0.0	8.0	8.0	25
6-аас дээш жил	92.7	7.3	21.8	3.6	16.4	12.7	29.1	55
НИЙТ	92.6	4.9	19.8	2.5	11.1	11.1	22.2	81

*1 оролцогч дутуу мэдээлэл өгсөн; олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Ирэх 5 жилийн хугацаан дахь бизнесийн трендийг сонирхоход, давхардсан тоогоор оролцогчдын 44.4 хувь “одоогийн хэмжээнд бие даан хөгжүүлнэ”, 58.0 хувь “өртгийн сүлжээнд нэгдэнэ”, 4.9 хувь нь “тодорхойгүй/мэдэхгүй” гэсэн хариултыг өгчээ. Эндээс үзэхэд бүсийн онцлогтой нэмүү өртгийн сүлжээ баруун бүсэд байгуулах нь чухал болохыг харуулж байна. Жимс, жимсгэнэ болон суулгац, үр, навч зэрэг дагалдах бүтээгдэхүүний төрөл зүйлтэй уялдуулан бүсийн төв, борлуулалтын суваг байгуулах боломжийн талаар судалгаа явуулах шаардлагатай. (Зураг 1)

Зураг 1



Зураг: Д.Саруул, НҮБХХ

Цаашид санал болгож буй үйл ажиллагаа

Бодлого, төлөвлөлт

- Орон нутгийн удирдлагууд бүсийн хэмжээнд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих зорилтоо биелүүлэх.
- Жимс, жимсгэнэ тариалагчдын өнөөгийн чадавх, ноу-хау, технологид суурилан бүсийн төв, хоршоо байгуулахад орон нутгийн удирдлагуудад бодлогын дэмжлэг үзүүлэх.
- Жимс, жимсгэнэ, түүний дагалдах бүтээгдэхүүнд тулгуурласан бүсийн төв эсвэл борлуулалтын суваг байгуулах.
- Баруун бүсийн аймгуудад тохиромжтой жимс, жимсгэний нэмүү өртгийн сүлжээний тогтолцоо, бүтэц сонгох.
- Тухайн бүсэд хамгийн тохирох бизнесийн загвар, жимс жимсгэний нэмүү өртгийн сүлжээний зураглал боловсруулах.
- Бүсийн усны хомсдол, хөрсний элэгдэл, хуурайшилт, улирлын шилжилт зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг харгалзан орон нутгийн удирдлагаас бүсийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

Технологи, ноу-хау болон хүний нөөц

- Жимс, жимсгэнэ, түүний дагалдах бүтээгдэхүүн болох үр, суулгац, навч, тэдгээрийн хэрэглээний талаар судалгаа, сургалт зохион байгуулах.
- Баруун бүсийн аймаг бүрт мэргэжлийн агрономичийн ажлын байр бий болгох.
- Жимс, жимсгэнэ тариалагчдад арга технологийн мэргэжлийн заавар, сургалт, зөвлөлгөө өгөх.

- Орон нутагт урамшууллын тогтолцоо бий болгох замаар хөдөө аж ахуй, ялангуяа агро аж ахуй эрхлэхэд хөдөлмөрийн насны иргэдийг татан оролцуулах, хөдөө аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийн талаар олон нийтэд сурталчлан таниулах.
- Орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглах, тэдгээрийн норм, нормативын тухай мэдлэг нэмэгдүүлэхийн зэрэгцээ орчин үеийн технологи ашиглахад дэмжлэг үзүүлэх санхүүгийн механизмийг илрүүлэн хэрэгжүүлэх.
- Хөргүүртэй машинаар зөөвөрлөх, зохих байршилд орон нутгийн хөргүүртэй агуулах, логистикийн төв байгуулах зэргээр тээвэрлэлт, логистикийн шийдлийг сайжруулах.
- Жимс, жимсгэнэ шинээр хадгалах стандарт хангасан агуулахын барилга байгууламж нэмэгдүүлэх.
- Жимс, жимсгэнэ тариалахад хамгийн тохиромжтой усжуулалтын системн технологийг тодорхойлон нутагшуулах.

Бизнесийн орчин

- Баруун бүсийн аймаг тус бүрийн орон нутгийн онцлог бүтээгдэхүүн сонгож, газар зүйн заалттай болж, шинэ зах зээлд нэвтрэх боломжоор хангах.
- Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдүүлэх дэд бүтэц, үйлдвэр байгуулах.
- Орон нутгийн бизнесийн орчинг өргөжүүлэхэд шаардлагатай худалдааны урсгал, логистик сайжруулах холбогдох арга хэмжээ авах.
- Газар өмчлөх, ашиглах эрх олгох, банкны зээл авах зэрэг тулгарч буй ерөнхий саад бэрхшээлийг багасгах.
- Жимс, жимсгэний нэмүү өртгийн сүлжээ байгуулсны дараа кластер байдлаар хөгжүүлэхэд анхаарах.
- Орон нутгийн нэмүү өртгийн сүлжээ байгуулснаар Баруун бүсийн өрсөлдөх чадвар, давуу талыг сайжруулах.

Ашигласан материал

1. Улаанбаатар хот, 2020, “Жимс, жимсгэний үндэсний хөтөлбөр”-ийн үнэлгээний тайлан
2. Улаанбаатар хот, 2020, Монгол Улсын Засгийн Газрын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого
3. Улаанбаатар хот, 2021, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
4. Улаанбаатар хот, 2021, Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн
5. Улаанбаатар хот, 2021, Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн
6. Улаанбаатар хот, 2018, “Газрын төлөв байдал, чанар, тохиромжтой байдлын үнэлгээ”, З.Мягмаржав И., Мягмарцэрэн П.
7. Хүн амын өсөлтийн хэтийн төлөв 2020-2050
8. Улаанбаатар хот, 2022, “Статистикийн мэдээ”
9. Улаанбаатар хот, Монгол Улсын Зам тээвэр, хөгжлийн яам, 2009, Баруун бүсийн нутгийн хөгжлийн төсөл
10. ХААИС-ын Агроэкологийн сургууль, 2023, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жимс, жимсгэний сортыг тодорхойлох, газрын тохиромжтой байдлын үнэлгээний тайлан.

Зохиогч

Долгорсүрэнгийн Саруул, НҮБХХ-ийн Уур амьсгалын төслүүдийн үндэсний зохицуулагч
Самбуунямын Золзаяа, НҮБХХ-ийн СКАЛА төслийн мэргэжилтэн

Редактор

Криб Ситатхани, НҮБХХ-ийн Ази, Номхон далайн Уур амьсгалын амлалт, СКАЛА төслийн бүсийн зохицуулагч
Шовон Кибриа, НҮБХХ-ийн Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөтөлбөр, байгаль орчин, уур амьсгал, эрчим хүчний багийн хувийн хэвшлийн оролцооны мэргэжилтэн

Хариуцлага

Энэхүү нийтлэлд илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчийнх бөгөөд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, хандивлагч байгууллагууд эсвэл НҮБ-ын гишүүн орнуудын үзэл бодлыг илэрхийлэх албагүй.

Зохиогчийн эрх @UNDP 2024. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

СКАЛА: Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН) болон Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний (ҮДЗТ) зорилтыг Хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ахиулахад дэмжлэг үзүүлэх төсөл нь Германы Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах яамны “Олон улсын уур амьсгалын санаачлагаас (IKI)” санхүүждэг. СКАЛА төсөл нь хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах шаардлагатай нэн яаралтай асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлдэг. Африк, Ази, Латин Америкийн 12 улс оронд дасан зохицох чадавхийг бэхжүүлж, хүлэмжийн хий бага ялгаруулах тэргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа хөтөлбөр юм.

Эдгээр дэмжлэгт бодлого сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход инновац ашиглах, мэдээллийн тунгалаг байдал, засаглал, санхүү, жендэрийн эрх тэгш байдлын цогц хандлага, нэгдсэн мониторинг, тайлагналтай холбоотой саад тотгорыг арилгах асуудал багтсан. Эдгээр өөрчлөлтийг авчрахад СКАЛА төслөөс хувийн хэвшлийн болон үндэсний гол байгууллагуудыг оролцоог ханган ажиллана.

СКАЛА төсөл нь улс орнуудыг Тогтвортой Хөгжлийн Зорилт болон Парисын хэлэлцээрийн дагуу ҮТХН, ҮДЗТ-нд тусгасан зорилтоо биелүүлэх чадавхиа бэхжүүлж, манлайлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. СКАЛА төслийг НҮБ-ын ХХААБ болон НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлсэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөнд хөдөө аж ахуйг нэгтгэх нь (2015-2020) хөтөлбөрийн суурь дээр санаачилсан.

**Нэгдсэн үндэстний байгууллагын
Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага**
www.fao.org/in-action/scala/en

**Нэгдсэн үндэстний байгууллагын
хөгжлийн хөтөлбөр**
www.adaptation-undp.org/scala

СКАЛА Монгол төсөл
Нэгдсэн үндэстний байгууллагын
хөгжлийн хөтөлбөр
Өрөө #409, Блю Скай
Энх тайвны гудамж 17,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот, Монгол улс
<https://www.mn.undp.org/>

Supported by:



Federal Ministry
for the Environment, Nature Conservation,
Nuclear Safety and Consumer Protection



INTERNATIONAL
CLIMATE
INITIATIVE

based on a decision of
the German Bundestag